



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/252

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын нийтийн эзэмшлийн талбайд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлж, суурилуулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөн булаг” ХХК-тай 84 123 200 /наян дөрвөн сая нэг зуун хорин гурван мянга хоёр зуу/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /А.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөн булаг” ХХК-ийн захирал /Б.Өлзийбаяр/-д даалгасугай.

4. Энэхүү ажлын санхүүжилтыг холбогдох хууль, журмын дагуу 2019 оны Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ



D:\ЗДТГ,ХОХБТХ\Захирамж

20190276